

ШИНЭЧИЛСЭН

ЭМС-ын А/513 тоот тушаалын дагуу
ММЭнН-ийн тэргүүлэгчдийн 2024.01.19ны
өдрийн хурлаар хэлэлцэн батлав



“Мэдээгүйжүүлэг судлал” мэргэшлийн зэрэг горилогчид

тавигдах тусгай шалгуур

1. “Мэдээгүйжүүлэг судлал” мэргэшлээр ахлах зэрэг шинээр горилогчдод тавигдах шалгуур:

1.1. Бүтээлийн жагсаалтанд дараах зүйлсийг заавал хангасан байх: /хамгийн багадаа нийт тоо – 3/

- Судалгааны өгүүлэл **заавал** (хамгийн багадаа 1) байх ба MMS стандартын аль нэг сэтгүүлд хэвлүүлсэн байх
- Бусад бүтээлүүдээс ММЭнН-ийн “Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ” сэтгүүлд **заавал** 1 болон бусад MMS стандартын аль нэг шинжилгээ судалгааны сэтгүүлд 1-с доошгүй өгүүлэл (онолын, тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлсэн байх – нийт 2

Жич:

- Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана.
- Хэрэв хэвлэн нийтлүүлсэн материалууд нь нэг сэдэвтэйгээр 1-с олон хэвлэлд хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн 1 хэвлүүлсэн материалаар тооцно.
- Бүтээлийн жагсаалтыг нийт бүтээлээр хүснэгтээр гаргаж хавсаргасан байх

1.2. Мэргэжлээрээ ажилласан 8 жилд хийсэн ажлын тайлан болон ММЭнН-ийн үйл ажиллагаанд оролцсон тайлан – ММЭнН-с гаргасан тайлангийн загвараар

2. “Мэдээгүйжүүлэг судлал” мэргэшлээр тэргүүлэх зэрэг шинээр горилогчдод тавигдах шалгуур:

2.1. Бүтээлийн жагсаалтанд дараах зүйлсийг заавал хангасан байх ба Ахлах зэрэг хамгаалснаас хойшхи хугацаанд хамгийн багадаа нийт тоо – 4

- Судалгааны өгүүлэл **заавал** (хамгийн багадаа 2) байх ба ММЭнН-ийн “Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ” сэтгүүлд **заавал** 1 ба MMS стандартын аль нэг сэтгүүлд 1-с доошгүй хэвлүүлсэн байх
- Бусад бүтээлүүдээс ММЭнН-ийн “Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ” сэтгүүлд **заавал** 1 болон бусад MMS стандартын аль нэг шинжилгээ

судалгааны сэтгүүлд 1-с доошгүй өгүүлэл (онолын, тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлсэн байх – нийт 2

Жич:

- Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана.
 - Хэрэв хэвлэн нийтлүүлсэн материалууд нь нэг сэдэвтэйгээр 1-с олон хэвлэлд хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн 1 хэвлүүлсэн материалаар тооцно.
 - Бүтээлийн жагсаалтыг нийт бүтээлээр хүснэгтээр гаргаж хавсаргасан байх
- 2.2. Мэргэжлээрээ ажилласан 5 жилд хийсэн ажлын тайлан болон ММЭнН-ийн үйл ажиллагаанд оролцсон тайлан – ММЭнН-с гаргасан тайлангийн загвараар
- 2.3. Мэдээгүйжүүлэг судлалаар заавал мэргэжил дээшлүүлсэн байх
- Хүүхдийн мэдээгүйжүүлэг, эх барихын мэдээгүйжүүлэг, ерөнхий мэдээгүйжүүлгийн мэргэжил дээшлүүлэх дотоодын сургалтуудад **эсвэл**
 - Эрчимт эмчилгээний болон яаралтай тусламжийн мэргэжил дээшлүүлэх дотоодын сургалтуудад **эсвэл**
 - Гадаадад мэдээгүйжүүлэг судлалын чиглэлээр 1 сараас дээш хугацаанд суралцсан байх, үүнийг нотлох баримтыг хавсаргах **эсвэл**
 - АУ-ны болон АШУ-ны магистрын зэргийг өөрийн мэргэжлийн чиглэлийн дагуу хамгаалсан байх

Жич: Өөрийн мэргэжлийн чиглэлээс бусад чиглэлээр хамгаалсан эрдмийн зэргийг болон бусад нарийн мэргэжил эзэмшсэн /жбл: гемодиализ, эхо гэх мэт/ бол мэргэжил дээшлүүлсэн байдалд оруулан тооцохгүй

- 2.4. Шинээр суралцагч эмч мэргэжилтнийг дагалдуулан сургасан байх өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшүүлсэн талаарх тайлан, зургаар баталгаажуулах
- 2.5. Тасаг нэгж, эмнэлгийн хэмжээнд залуу эмч, сувилагчийн сургалтад оролцож хичээл заадаг – хичээлийн хөтөлбөр ба бусад материалаар баталгаажуулах

3. **“Мэдээгүйжүүлэг судлал” мэргэшлээр зөвлөх зэрэг шинээр горилогчдод тавигдах шалгуур:**

- 3.1. Өмнөх зэрэг хамгаалснаас хойших Бүтээлийн жагсаалт гаргасан байх

Бүтээлийн жагсаалтанд дараах зүйлсийг **заавал хангасан** байх ба **Тэргүүлэх** зэрэг хамгаалснаас хойшхи хугацаанд хамгийн багадаа нийт тоо – 5

- Судалгааны өгүүлэл **заавал** (хамгийн багадаа 2) байх ба ММЭнН-ийн “Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ” сэтгүүлд **заавал 1** ба MMS стандартын аль нэг сэтгүүлд 1-с доошгүй хэвлүүлсэн байх
- Бусад бүтээлүүдээс ММЭнН-ийн “Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээ” сэтгүүлд **заавал 1** болон бусад MMS стандартын аль нэг шинжилгээ судалгааны сэтгүүлд 2-с доошгүй өгүүлэл (онолын, тойм ба судалгааны өгүүлэл) нийтлүүлсэн байх – нийт 3

Жич:

- Дээрх өгүүлэл, илтгэлийн эхийг хуулбарлан хувилж (гарчиг ба өгүүлэл, илтгэл) хавсаргана.
 - Хэрэв хэвлэн нийтлүүлсэн материалууд нь нэг сэдэвтэйгээр 1-с олон хэвлэлд хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн 1 хэвлүүлсэн материалаар тооцно.
- 3.2. Мэргэжлээрээ ажилласан жилийн хийсэн ажлын тайлан болон ММЭнН-ийн үйл ажиллагаанд оролцсон тайлан – ММЭнН-с гаргасан тайлангийн загвараар
- 3.3. Мэдээгүйжүүлэг судлалаар заавал мэргэжил дээшлүүлсэн байх
- Хүүхдийн мэдээгүйжүүлэг, эх барихын мэдээгүйжүүлэг, ерөнхий мэдээгүйжүүлгийн мэргэжил дээшлүүлэх дотоодын сургалтуудад **эсвэл**
 - Эрчимт эмчилгээний болон яаралтай тусламжийн мэргэжил дээшлүүлэх дотоодын сургалтуудад **эсвэл**
 - Гадаадад мэдээгүйжүүлэг судлалын чиглэлээр 1 сараас дээш хугацаанд суралцсан байх, үүнийг нотлох баримтыг хавсаргах **эсвэл**
 - АУ-ны болон АШУ-ны магистрын болон докторын зэргийг өөрийн мэргэжлийн чиглэлийн дагуу хамгаалсан байх
 - АУ-ны болон АШУ-ны магистрын зэрэгтэй бол клиникийн профессор цолтой байх
- Жич: Өөрийн мэргэжлийн чиглэлээс бусад чиглэлээр хамгаалсан эрдмийн зэргийг болон бусад нарийн мэргэжил эзэмшсэн /жбл: гемодиализ, эхо гэх мэт/ бол мэргэжил дээшлүүлсэн байдалд оруулан тооцохгүй
- 3.4. Мэргэжлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн, өөрийгөө орлох хэмжээний шавь нарыг бэлтгэсэн байх - Шавь бэлтгэсэн үйл ажиллагааны тайланд нотлох баримтуудыг тусгах ба байгууллагаараа баталгаажуулсан байх
- 3.5. Ажиллах хугацаандаа дараах бүтээлийн жагсаалтнаас хамгийн багадаа 4-с доошгүйг заавал биелүүлсэн байх

- Өөрөө бичиж хэвлүүлсэн ном болон хамтран бүтээсэн номын тоо 2-оос доошгүй байх **эсвэл**
- Гаргаж баталгаажуулсан оношилгоо, эмчилгээний удирдамжийн тоо 3-оос доошгүй **эсвэл**
- Зохиогчийн эрх, ашигтай загвар, оновчтой саналын гэрчилгээний аль нэгийг авсан байх **эсвэл**
- Эмнэлзүйн практикт бодитоор нэвтрүүлж үр дүнгээ өгсөн шинэ арга 2-оос доошгүй байх ба үүнийг байгууллагын түвшинд баталгаажуулсан байх

4. “Мэдээгүйжүүлэг судлал” мэргэшлээр ахлах зэрэг шинэчлэн тогтоох горилогчдод тавигдах шалгуур:

Энэ нь “Мэдээгүйжүүлэг судлал” ахлах зэрэг шинээр горилогчдийн шалгууртай ижил байх ба харин онолын болон дадлага шалгалт өгөхгүй тайлан хамгаалалт хийж “Ахлах” зэргээ шинэчлэн батална.

5. “Мэдээгүйжүүлэг судлал” мэргэшлээр тэргүүлэх зэрэг шинэчлэн тогтоох горилогчдод тавигдах шалгуур:

Энэ нь “Мэдээгүйжүүлэг судлал” тэргүүлэх зэрэг шинээр горилогчдийн шалгууртай ижил байх ба харин онолын болон дадлага шалгалт өгөхгүй тайлан хамгаалалт хийж “Тэргүүлэх” зэргээ шинэчлэн батална.

6. “Мэдээгүйжүүлэг судлал” мэргэшлээр зөвлөх зэрэг шинэчлэн тогтоох горилогчдод тавигдах шалгуур:

Энэ нь “Мэдээгүйжүүлэг судлал” зөвлөх зэрэг шинээр горилогчдийн шалгууртай ижил байх ба тайлан хамгаалалт хийж “Зөвлөх” зэргээ шинэчлэн батална.